

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН СУРГАЛТЫН ОРЧНЫ БҮРДЭЛТ (Туршигдагч “Бэлтгэл” бүлгийн жишээн дээр)

Т.Гэрэлтуяа, МУБИС

Abstract

This study investigates the result of the hygiene, safety and formation of indoor play environments for “5-year-old children” and of the equity, supply and needs of teaching and play materials according to “The criteria of child friendly kindergarten”. The purpose of this paper is to identify which play center makes the boys and girls choose to play during the class. We used the questionnaire with kindergarten teachers, 20 children and their parents and compared to personal observation. The result of this case study, parents who participated in the survey identified the learning environment as healthy and safe, but it needs to be improved. For example, it is important to constantly increase the access to play and equip, to constantly work with parents and to adjust the number of children according to the class level. And the age group of 5 years old was covered by the survey due to the requirements of the instructional environment, which was sufficient and accessible. The teacher has updated the learning environment for each topic every week at each playing center, adding new toys and teaching materials, and having difficulty with each toys.

Түлхүүр үг

Багш, эцэг эх, хүүхэд, сургалтын орчин, төвийн сонголт

СӨББ-ын сургалтын орчны талаар

Сургалтын орчин гэдэг нь: Сургалт- сурах үйлийн нэр, орчин- хавь ойр, ойр орчим гэсэн утга агуулж байна. (Я.Цэвэл, 1966, х.930)

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрт:

- Хүүхдийн орчин нь ая тухтай, эрүүл мэнд, хөдөлгөөн, тоглох үйлийг дэмжсэн эерэг харилцааг үүсгэх, эрэл хайгуул хийхэд өдөөсөн, суралцахуйн хөгжлийг дэмжсэн байна.
- Хүүхдийн бие махбод, сэтгэл хөдлөл, зан чанар, харилцаа, сэтгэн бодох болон сурах арга барилд нөлөөлөхийн зэрэгцээ харилцан хамааралтай, уян хатан байна.
- Сургалтын орчин нь материаллаг орчин, үйлийн орчин, сэтгэлзүйн орчны шаардлагыг хангасан байна.

БСШУЯ-ны сайд Л.Гантөмөрийн баталсан 2013.8.28 өдрийн А\327-р тушаалын 4.1.2-т орчин бол “Туравдагч багш” юм. Оновчтой бүрдүүлсэн сургалтын орчин нь хүүхдийн сонирхол, сэтгэлийг татаж, урам зориг оруулж, тэдний бүх талын хөгжилд нөлөөлдөг тул багш, эцэг эхээс гадна “Туравдагч багш”-ийн үүрэг гүйцэтгэнэ.



Елизабет Джонес сургалтын орчны таван хэмжээсийг гаргаж ирсэн. (Жанет Гонзалес-Мина, 2016, х.223, 224)

Цэцэрлэгийн сургалтын орчинг:

“Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үнэлгээ”-ээс

- Эрх тэгш хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байдал
- Орчны ариун цэвэр, эрүүл ахуйн байдал
- Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний сонголт, хүртээмж, чанар гэсэн 3 үзүүлэлтийг багцлан авсан ба дотроо дараах агуулгыг багтаасан.

Судалгааны зорилго: ЧД-ийн туршигдагч 83-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн сургалтын орчны бүрдэлт, хүртээмж, хангамжийг багцлан бүлгийн багш, эцэг эх, ажиглагчийн судалгааг харьцуулан үр дүнг тооцон гаргах

Судалгааны арга

- Асуулгын арга
- Харьцуулан жиших арга

Хүснэгт 1

Цэцэрлэгийн сургалтын орчны үнэлгээний шалгуур

Үнэлгээний шалгуур	Эх үзүүлэлтүүд	Үнэлгээний баримт цуглуулах арга, хэрэглүүр
Эрх тэгш хүртээмжтэй орчин		
Эрх тэгш хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байдал	• Байгууламж, тоноглол нь бүх хүүхдэд тохиромжтой, нас болоод хөгжлийн онцлогт нийцсэн эсэх • Бие бялдрын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд биеийн тамирын хичээл, тоглоомд оролцох боломжийг хангасан эсэх • Сандал, ширээ, тоглоом, ор, бусад хэрэглэгдэхүүн материал бүх хүүхдэд хүрэлцээтэй эсэх • Анги танхимын хичээл, тоглоомын булангууд нь хүүхэд ганцаараа болон бүлгээр ашиглахад хүрэлцээтэй эсэх • Номын сангийн баяжилт, түүний хүртээмж хангалттай эсэх	• Цэцэрлэгийн байгууламж, тоног хэрэгсэл, тэдгээрийн ашиглалтад ажиглалт хийх • Анги танхим, хичээлийн буланг ажиглах • Цэцэрлэгийн багш, туслах багштай ярилцах
Эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчин		
Орчны ариун цэвэр, эрүүл ахуйн байдал	• Эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй ундны усаар хангагддаг эсэх • Тоглоом, наадгай, сургалтын хэрэглэгдэхүүн, үзүүлэнгийн материал нь эрүүл ахуйн шаардлагыг хангасан эсэх • Охид, хөвгүүдийн бие засах, гар угаах газар хүрэлцээтэй, хэвийн ажилладаг эсэх • Эко орчинг хангалттай бүрдүүлсэн эсэх • Халдварт өвчин гарахаас сэргийлэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн эсэх • Төсөвт цэвэрлэгээний материал, ариутгалын бодис худалдан авах зардал хангалттай тусгагдсан эсэх	• Багш, эцэг эхээс асуулга авах • Ажиглалт хийх
Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний байдал		

Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний сонголт, хүртээмж, чанар	• Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь хүйсийн мэдрэмжтэй эсэх • Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь соёл, нийгмийн байдлаараа ялгаатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлогт зохицсон эсэх • Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэх • Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг хүүхдүүд ганцаараа болон хамтран хэрэглэхэд хүртээмжтэй эсэх • Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь хүүхдийн сонирхол, хэрэгцээг хангадаг эсэх • Тоглоом, хэрэглэгдэхүүнийг хүүхэд сонгох боломжтой эсэх • Багш тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг хүүхдэд сонирхолтой сэдэв, агуулгатай уялдуулан бэлтгэж, булан төвүүдэд байрлуулдаг эсэх	• Багш, эцэг эхээс асуулга авах • Багш нарын үйл ажиллагаанд ажиглалт хийх • Хүүхдийг ажиглах
--	---	---

Багш, эцэг эх, ажиглагчаас авах судалгааны чиглэл

Шалгуур, үзүүлэлт

1. Цэцэрлэг нь эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангадаг
2. Бүлгийн тоглоом наадгай нь цэвэрхэн, аюулгүй
3. Хүүхдүүд цэцэрлэг дээрээ зориулалтын, цэвэрхэн бие засах, гар угаах газрыг ашигладаг
4. Бүлэгт тасалгааны ургамал тарьж, ногоон орчин бүрдүүлсэн
5. Бүлэг нь халдварт өвчнөөс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн
6. Бүлэгт осол, аюулгүй байдлын дүрмийг мөрддөг
7. Анги танхим, цэцэрлэгт засвар хийж шинэчилсэн
8. Цэцэрлэгийн гадна дотно аюулгүй, найдвартай тоглоом, хэрэглэгдэхүүнийг ашигладаг
9. Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг хүүхдүүд ганцаараа болон хамтран хэрэглэхэд хүртээмжтэй байдаг
10. Бүлэгт тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь хүүхдийн сонирхол, танин мэдэх хэрэгцээг хангадаг зэрэг үзүүлэлтийг боловсруулж доорх хүснэгт дэх үнэлгээгээр үнэлэхийг зөвлөж тайлбар өгсөн болно. Үүнд:

Та хүүхдийн бодит байдлын өгөгдсөн бодомжуудын санаатай хэр ойр байгаагаар баримжаалж хариултыг сонгоорой. Хариулах боломжгүй, юу гэж хариулахаа сайн мэдэхгүй бол “Х” буюу мэдэхгүй гэсэн баганын харгалзах мөрөнд тэмдэглэгээ хийнэ үү. Сэтгэл дундуур байгаа хариултдаа тайлбар бичвэл сайн. Таны хариулт бодитой байхын хэрээр цэцэрлэг, багш нарын үйл ажиллагааг цаашид сайжруулах чиг санаа зөв гарах тул аль болох бодитой, үнэн зөв хариулахыг хичээгээрэй.


Хүснэгт 2

Багш, эцэг эх, ажиглагчаас авах шинжилгээний хуудасны загвар

	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай.	Үгүй	Мэдэхгүй	Тайлбар
Хүүхдийн суралцаж, хөгжиж байгаа орчин				Х	

Диаграмм 1


Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн оролцооны байдлын нэгтгэл



Судалгаанд хамрагдсан 20 эцэг эхийн 44 хариултыг хувьчлан авч үзвэл: Тийм-10%, сайжруулах шаардлагатай -85%, мэдэхгүй- 15%-ийн санал өгч оролцсон байна.

Диаграмм 2


Судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн оролцооны нэгтгэл



Дээрх диаграммаас харахад 20 эцэг, эхийн нийт асуулгыг нэгтгэхэд 66,5% нь сургалтын орчинг хангалттай сайн, 28% нь сайжруулах шаардлагатай, 4% нь мэдэхгүй, 2% нь үгүй гэсэн хариултыг сонгосон байна.

Диаграмм 3

Эцэг эх, багш, ажиглагчдын орчны талаарх харьцуулалт



Сургалтын орчны талаарх эцэг эх, бүлгийн багшийн судалгааг ажиглагчийн ажиглалттай харьцуулан үр дүнг гаргасан. Нийт үр дүнг

харьцуулахад багш, ажиглагч нар сургалтын орчинг 100% хангалттай сайн гэж үзсэн бол эцэг, эх 66,5% нь хангалттай гэж үзжээ.


Хүснэгт 3

Сургалтын орчны талаар судалгаанд өгсөн санал, дүгнэлт

1. Эрх тэгш хүртээмжтэй орчин 2. Эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчин 3. Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний сонголт, хүртээмж, чанар			
Мэдээллийн эх үүсвэр	Хангалттай	Хангалтгүй	Тайлбар
Эцэг эх, асран хамгаалагч	+		Сургалтын орчин нь эрүүл ахуй, стандартын шаардлага хангаж байгаа ч сайжруулах шаардлагатай зүйлс байна. Ж нь: Тоглоом, хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулах
Багш	+		Сургалтын орчинд байх тоглоом, хэрэглэгдэхүүн хүүхэд бүрд хүрэлцээтэй, чанар стандартыг хангасан. Сэдвийн дагуу тогтмол баяжилт хийгддэг.
Цэцэрлэгийн орчинд хийсэн ажиглагчийн ажиглалт	+		Цэцэрлэгийн дотоод орчинд байх тоглоом, хэрэглэгдэхүүн, эд хогшил зэрэг нь хүүхэд бүрд хүрэлцээтэй, эрүүл ахуй, чанарын шаардлага хангасан байлаа. Хүүхдийн өөрийн сонирхол дээр тулгуурлан хүүхдийг хөгжүүлж байв.

Диаграмм 4

Туршигдагч “Бэлтгэл” бүлгийн хүүхдийн сургалтын орчны сонголтод харьцуулалт хийсэн байдал



Туршигдагч бэлтгэл “А” бүлгийн 20 хүүхдийг санамсаргүй байдлаар сонгон авч ажиглахад ангид байгаа сургалтын төвөөс тоглоомын төв 35%, математикийн төв 30%, хэл яриа, дүрслэх урлагийн төв 15%, байгаль туршилт танин мэдэхүйн төв нь 5%-тайгаар оролцож байлаа. Хүүхдүүдийг ажиглаж байхад хөвгүүд голдуу өрж байгуулах, эвлүүлдэг тоглоомоор тоглож байхад, охидууд математик, дүрслэхийн төвийг сонгож байна. Хүүхэд бүрийн төвийн сонголтыг тус бүрээр нь тэмдэглэн, дунджийг гаргахад тухайн гарсан дүн нь 7 хоногт 2 удаагийн давтамжтай сонгогдсон байв.

Дүгнэлт

1. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих чухал зүйл бол орчин юм. Орчин нь хүүхдийн суралцах сонирхлыг өдөөсөн, эрэл хайгуул хийх боломжийг олгохуйц, хүүхдийн хөдөлгөөнийг дэмжсэн, эрүүл, осол аюулгүй байдлыг хангасан байх шаардлагатай. Сургалтын орчин нь материаллаг, үйлийн, сэтгэлзүйн гэсэн бүрдлээс бүрдэх ба өөр өөрийн шаардлагыг хангасан байна.
2. Цэцэрлэгийн сургалтын орчинг “Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үнэлгээ”-ээр судлахдаа эцэг эх, багш, ажиглагч нарыг хамруулан авсан нь судалгааны дүн бодит гарахад илүү дөхөм болсон.
3. Судалгаанд оролцсон эцэг, эхчүүд сургалтын орчинг эрүүл, аюулгүй байна гэж тодорхойлсон хэдий ч сайжруулах шаардлагатай зүйлс байна гэж үзсэн. Тухайлбал тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг тогтмол нэмэгдүүлэх, эцэг, эхчүүдийг багштай байнга хамтран ажиллаж байх хэрэгтэй, ангийн хэмжээнд тохируулан хүүхдийн тоог тохируулах нь чухал гэж дүгнэсэн.
4. Туршигдагч бүлгийн хүүхдүүд өөрийн хүссэн

сонголтоороо төвүүдийг сонгож, дуртай тоглоом, хэрэглэгдэхүүнээ сонгон авч, чөлөөтэй тоглож байлаа. Сарын хугацаанд хүүхдийн сонголтод ажиглалт хийхэд хөвгүүд голдуу тоглоомын төвийг сонгож, эвлүүлэх, өрж байгуулдаг тоглоомоор тоглож байсан бол охидууд дүрслэн урлах, математикийн төвийг голдуу сонгож байлаа. Хамгийн их сонгогдож байгаа төв нь тоглоомын төв 35%, бага сонгогдож байгаа нь байгаль туршилт танин мэдэхүйн төв 5% байсан.

5. Судалгаанд хамрагдсан бэлтгэл бүлэг нь сургалтын орчны шаардлагыг хангасан, хүрэлцээ, хүртээмж сайтай байсан. Багш нь сургалтын орчноо тухайн сэдвийн дагуу 7 хоног бүр, төв болгон дээрээ нэг тоглоом, хэрэглэгдэхүүн нэмж, шинээр хийж баяжуулан, тоглоом бүр нь аргачлалтай, хөнгөнөөс хүндэрсэн хувилбаруудтай байсан нь бага насны хүүхдийн үндсэн үйл тоглоом гэдгийг баталж байна.

Ашигласан материал

БСШУЯ. (2015). Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар:

БСШУЯ. (2013). Хүүхэд нэг бүрийн хөгжлийн төлөө. Улаанбаатар

Батдэлгэр, Ж., Баттуяа,Ц., Алтансувд,Л. (2013). Хүүхдэд ээлтэй багшийн арга зүй сургалтын модуль. Улаанбаатар

Жанет Гонзалес- Мина.(2016). Соёлын баялаг, ялгаатай орчинд багшлах нь - бага насны боловсролын үндэс. Улаанбаатар

https://www.unicef.org.mongolia.Khuukhded_eeltei_tsetserlegiin_unelgee-1.pdf